МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.01.21 № 01/424
танай -ны № -т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГА А.БАЯР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг үндэслэн Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлаас үүсэх метан хийг устгах төсөл, хог хаягдлыг сэргээн ашиглаж, эрчим хүч гаргах үйлдвэр байгуулах тухай тогтоолын төслийг боловсруулан өргөн барьж байна.

Тус тогтоолын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж өгөхийг хүсье.

Хавсралт 7 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1725060297

УЛААНБААТАР ХОТЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хаяг: Сүхбаатарын талбай, Сүхбаатарын нэрэмжит дүүрэг, Монгол Улс, 14200
Утас: 70 - 11 - 11 - 11, 99 - 66 - 99 - 99
Цахим хуяг: www.ulaanbaatar.mn

Дугаар: А/ХУД/2025/01

Огноо: 2025 оны 01 дүгээр сарын 09

Хот байгуулалтын асуудлыг зохицуулах газрын дарга Ц.Ганбаатарт

Хот байгуулалтын асуудлыг зохицуулах газрын дарга Ц.Ганбаатарт

Хотын Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалтын асуудлыг зохицуулах газрын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/ХУД/2025/01 тоот албан бичгийг хүлээн авлаа. Та бүхний зүгээс Хотын Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалтын асуудлыг зохицуулах газрын Ерөнхий мэргэжилтэн Ж.Мөнхсайхан, Ерөнхий мэргэжилтэн Ц.Ганзориг нарыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09:00 цагаас эхлэн Хотын Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд ажиллах зөвшөөрөлтэй болгосон тухай мэдэгдэж байна.

Хотын Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалтын асуудлыг зохицуулах газрын дарга Ц.Ганбаатарт хүндэтгэлтэй хандан ажиллах болно.

Хотын Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Мөнхсайхан

Ц.Ганзориг

Хотын Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалтын асуудлыг зохицуулах газрын дарга Ц.Ганбаатарт

Хотын Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Мөнхсайхан

1725060147

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 сарын 03 өдөр Дугаар 17 Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНД

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"2а.Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт хаягдлаас үүсэх метан хийг устгах төслийг хэрэгжүүлэх тухай асуудлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Г.Батзориг танилцуулав.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас:

1.Төвлөрсөн хогийн цэгт үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдүүдийн газар ашиглуулах эрхийг цуцлах асуудлыг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг), нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Мөнхбаатар)-нд;

2.Хог шатааж эрчим хүч гаргах үйлдвэрийг Морингийн даваанд төвлөрсөн хогийн цэг, Цагаан даваанд төвлөрсөн хогийн цэгт байгуулахаар төлөвлөлтийг хийх

- Дээрх 2 үйлдвэр байгуулах талаар Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд урилга боловсруулж, олон улсад үйл ажиллагаа явуулж буй 4-өөс доошгүй мэргэжлийн компанид хүргүүлэх

3.Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанд 2024 оны 12 дугаар сард багтаан танилцуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн эрчим хүчний асуудал хариуцсан зөвлөх (Р.Дагдан)-д;

3. Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт хаягдлаас үүсэх метан хийг устгах төслийг хэрэгжүүлэх тухай НИТХ-ын тогтоолын төсөлд төлөвлөж буй Хог шатааж эрчим хүч гаргах үйлдвэрийн газрын асуудлыг нэмж тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэн, тогтоолын төслийг 12 дугаар сарын 04-ний өдөр танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, тогтоомж гэрээ эрх зүйн газар (Д.Амгалан), Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг)-нд;

4.Хог хаягдлын менежментийн бодлогын баримт бичиг боловсруулах, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан төслийн нэгжийг байгуулах шийдвэрийн төсөл бэлтгэн 2024 оны 12 дугаар 20-ны өдрийн дотор танилцуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг)-нд;

6.Малын түүхий эдийг шатаах жижиг оврын үйлдвэр байгуулах талаар санал боловсруулж, 2024 оны 12 дугаар 20-ны өдрийн дотор танилцуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг)-нд;

7.Дээрх асуудлуудын хэрэгжилтийг улирал тутам гаргаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээний газар (Х.Гантулга)-т тус тус үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

УЛААНБААТАР ХОТЫН НАРАНГИЙН ЭНГЭРИЙН ХОГИЙН ЦЭГ (НЭХЦ) ЛАНДФИЛ БАЙГУУЛАМЖИЙН МЕТАН ХИЙГ ШАТААН УСТГАХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ

1. Төслийн явцын товч танилцуулга

А. Төсөл хэрэгжүүлэгч:

Монгол Улсын Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яам,
БНСУ-ын Байгаль орчны яам
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
БНСУ-ын "Судоквон Ландфил Сайт Менежмент Корпорэшн" ГХЭТГ – (Төрийн өмчит)

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүлэмжийн хийг бууруулах чиглэлийн БНСУ-ийн анхны төсөл болж байгаагаараа онцлог.

В. Төслийн санхүүжүүлэгч:

Төсөв хэрэгжүүлэгч : БНСУ-ын Байгаль Орчны Яам

Төсөвт өртөг: 14.5 тэрбум вон

С. Төсөл хэрэгжих хугацаа:

Төслийн үйл ажиллагаа 2022 оны 1-р сараас эхэлсэн ба БНСУ-ын тал 12 жилийн хугацаанд төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг бүрэн хариуцан хэрэгжүүлж Монгол талын хариуцагчийг дадлагажуулан сургаж, энэ чиглэлийн өөр төсөл хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх нөхцөл суурийг бэлтгэн, уг иж бүрэн байгууламжийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд үнэ төлбөргүй шилжүүлэн өгнө.

2. Нарангийн энгэр хогийн цэгийн өнөөгийн байдал:

А. Төслийн талбай:

- Улаанбаатар хотын төвөөс баруун хойд зүгт 10км-ын радиуст багтах зайнд оршиж байна.
- Нийт 360,000м2 буюу 36га талбайг хамарсан талбайтай. СХД-ын 36-р хорооны хүн амын суурьшлын бүс гэр хороллын айл өрхтэй хил залгаа байршдаг.
- Нийт хог хаягдлын хэмжээ ~ 5,400,000тн /2022 оны байдлаар/
- Ашиглалтын хугацаа – Хогийн цэгийг 2025 оныг дуустал хугацаанд ашиглаад хаах урьдчилсан төлөвлөгөөтэй.

В. Нарангийн энгэр хогийн цэгийн ашиглалтын байдал:

- Нийт талбайн 16га орчим талбайд ландфил хийж хогийг булсан бөгөөд үлдсэн 20га орчим талбайд хог асгалт, булалт хийгдэж байна.
- Хогийн цэгийн ойр орчим нарийн ширхэгт тоос, тоосонцор бохирдол асар их мөн ландфилл хийгдсэн талбайн хийн дэлбэрэлтээс хамгаалсан цооногын метан хий /CH4/-ний тархалтаас үүдэлтэй агаар мандлын бохирдол болон бохир үнэр үүсэж тархаж байгаа. Хаягдал хогийн цэгийн доторх органик бодис (хоол хүсний үлдэгдэл, цаас, мод зэрэг) нь хүчилтөрөгчийн дутагдлаас болж агааргүй дарагдсан орчинд

задрангаа метан (CH_4) болон нүүрстөрөгчийн давхар исэл (CO_2), бусад бохирдуулагч бодисыг бий болгон агаарт дэгдэх хүрээлэн орчин, уур амьсгалын өөрчлөлтөнд асар муугаар нөлөөлж байгаа. Метан хий нь агаараас хүнд учраас тухайн орчиндоо удаан хугацаанд тархан оршиж байдаг.





2 үе шат хогийн цэг | 2 үе шат төслийн булалт хийсэн нэмэлт талбай | Хий зайлуулагч | Байгууламж байрших

3. Төслийн үндэслэл, хүчин чадал, үр дүн

A. Төслийн үндэслэл шаардлага:

- Дэлхий нийтийн улс орнуудад тулгамдаж буй чухал асуудлын нэг бол хог хаягдал юм. Дэлхийн банкны "What a Waste 2.0: A Global Snapshot of Solid Waste Management to 2050" тайланд дурьдсанаар, дэлхий дээр жилд нийт 2.01 тэрбум тонн хог хаягдал үүсдэг байна. Цаашид хог хаягдлын хэмжээ улам нэмэгдэх бөгөөд 2050 он гэхэд 3.4 тэрбум тонн болох юм. Өсөн нэмэгдэж буй хог хаягдал нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд маш их сөрөг нөлөөтэй бөгөөд байгалийн нөөц баялгийн хомсдлыг бий болгож мөн уур амьсгалын өөрчлөлтөнд ч нөлөөлж байна.

- Улаанбаатар хотын хэмжээнд Нарангийн энгэр, Цагаан даваа, Морингийн даваа гэсэн төвлөрсөн 3 хогийн цэг байна. Эдгээрээс хамгийн том, Улаанбаатар хотын салхины чигийн дээр, өндөрлөгт байрлаж байгаа учир төсөл хэрэгжүүлэх эхний байршлаар сонгосон.

- Монгол улс нь уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр нэгдэн үүрэг хүлээсэн байгаа учраас хүлэмжийн хийн ялгарал багатай, тогтвортой хөгжлийн

зорилгод нийцсэн төсөл хөтөлбөр үйл ажиллагааг явуулах шаардлагатай. Иймд хогийн цэгээс ялгарах хүлэмжийн хийг бууруулах, хогийн менежментийг сайжруулах нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын чухал хэсгийн нэг болоод байна.

Нарангийн энгэр хогийн цэгийн нийт 36га талбайд булагдсан хог хаягдлаас ялгарч буй хүлэмжийн хийг бууруулах зорилгоор бид доорх тоног төхөөрөмж, байгууламжийг суурьлуулна. Үүнд:

- **Хийн босоо цооног : 76ш**

- 1-р үеийн Хийн босоо цооног : 38ш
- 2-р үеийн Хийн босоо цооног : 38ш

- **Цуглуулагч : 4ш**

- 1-р үеийн Цуглуулагч : 2ш
- 2-р үеийн Цуглуулагч : 2ш

- **Дамжуулах хоолой: 14,594m**
- **Хий шатаагч төхөөрөмж: 990Nm3/hr х 3ш байнгын 2, нөөцөнд 1)**
- **Аюулгүй ажиллагааны тоноглол**
- **Удирлагын байр: /12.6м * 8.6м/ 108.3м.кв хэмжээтэй**
- **Хий шатаах төхөөрөмжийн байр: /33м*18м/ 594м.кв хэмжээтэй.**



B. Төслийн үр дүн

Нарангийн энгэр хогийн цэгээс ялгарах метан хийг устгаж бууруулснаар бид дараах үр дүнг хүлээж байна. Үүнд:

- ✓ Хогийн цэгээс ялгарах метан хий, үнэр багасаж хүрээлэн буй орчинд эерэг нөлөөллийг бий болгож оршин суугчид эрүүл аюулгүй амьдрах нөхцөлөөр хангагдана.
- ✓ Төсөл хэрэгжих 12 жилийн хугацаанд ойролцоогоор 567 мянган тонн CO2-eq хүлэмжийн хийг багасгана
- ✓. Ландфил хийгдсэн хог хаягдлын цэгийн аюулгүй байдлыг хангана.

- ✓ Хог хаягдлын менежментийн чиглэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, сайжруулах бололцоо нэмэгдэнэ.
- ✓ Хогийн цэгийн өмхий үнэр, метан хийн ялгарал байхгүй болсноор эрүүл аюулгүй орчин үүсэж уг газар дээр ногоон байгууламж, мод үржүүлгийн талбай, гольфийн талбай, байгалийн цэцэрлэгт хүрээлэн зэрэг олон төрлөөр ашиглах боломж бүрдэх юм.

4. Монголын Наран энгэрийн хогийн цэг (NEDS) хүлэмжийн хий бууруулах төслийн зөвшөөрлийн явц

Бэлэн болсон | Хүлээгдэж байгаа

	Зөвшөөрөл	Огноо		Зөвшөөрлийн тайлбар	Бэлтгэл байдал	Холбогдох байгууллага
Үндсэн шаардлагатай зөвшөөрлүүд	① Техник эдийн засгийн үндэслэл батлуулах	Хүсэлт:	23.6.16	- ТЭЗҮ батлуулах (хөрөнгө оруулалт татах болон эдийн засгийн үндэслэл зэрэг)	- ТЭЗҮ тайлан (Монгол хэл дээрх тайлан)	Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам (хурлаар батлах)
		Баталсан:	24.3.29			
	② Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	Хүсэлт:	24.4.8	- Төслийн орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ - Хуульд заасан стандартад нийцэх эсэхийн хяналт	- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан	Байгаль орчин,уур амьсгалын өөрчлөлтийн яам
		Хурал:	24.8.26			
		Баталсан	24.10.22			
	③ Газар ашиглах зөвшөөрөл — Газар ашиглах гэрээ байгуулах Улаанбаатар хотын	Хүсэлт:	23.5.29	- Төсөл хэрэгжих газрын зөвшөөрөл - УБ хотын захирагчийн албаны тушаал ⓐ	- Газрын зөвшөөрөл хүссэн албан хүсэлт (Төлөөлөгчийн газар→Улаанбаатар хотын захирагчийн алба) - Кадастрын хэмжилт	Улаанбаатар хотын захирагчийн алба
		Баталсан:	23.7.24			
	Газар ашиглах гэрээ	Хүсэлт:	23.8.17	- Газар ашиглуулах гэрээний маягт - Хамтран ажиллах гэрээ ⓑ	- Гэрээний маягт (УБ хотын захирагчийн алба-Төлөөлөгчийн газар) - Гэрээ батлах	Улаанбаатар хотын захирагчийн алба
		Баталсан:	-			

	Архитектур төлөвлөлтийн даалгавар	Хүсэлт:	23.10.12	- Барилгын дэлгэрэнгүй төлөвлөгөө (хэмжээ, гэрэлтүүлэг, хот тохижуулалт зэрэг) - Архитектур төлөвлөлтийн даалгавар ⓒ	- Барилгын зураг батлуулах хүсэлт (Улаанбаатар хотын захирагчийн алба →Хот байгуулалт хөгжлийн газар) – Барилгын зураг танилцах	Улаанбаатар хотын захирагчийн алба (Хот байгуулалт хөгжлийн газар)
		Баталсан:	23.11.03			

Барилгын зөвшөөрлүүд	④ Эскиз (1-р шат)	Хүсэлт:	23.11.24	[Барилгын зөвшөөрөл] эскиз зураг болон төлөвлөгөө хяналт, шалгалт	- Эскиз зураг, зургийн дэлгэрэнгүй, кадастрын материал	Улаанбаатар хотын захирагчийн алба (Хот байгуулалт хөгжлийн газар)
		Баталсан:	23.12.28			
	⑤ Ажлын зураг (2-р шат)	Хүсэлт:	24.1 сарын эх	[Барилгын зөвшөөрөл] зураг, төсөв хяналт шалгалт	- Хэсэг бүрийн дэлгэрэнгүй зураг, төслийн төсвийн задаргаа	Барилга хөгжлийн төв Онцгой байдлын ерөнхий газар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
		Баталсан:	-			

※ Барилгын зөвшөөрөл хүсэлт гаргах болон батлуулахад Газрын зөвшөөрөл шаардлагатай байна.

Тулгамдаж буй асуудал:

Газрын тухай хуулийн 35.1.4, 35.1.6-д зааснаар Газар эзэмшигч /Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба/ газраа бусдад /Судоквон Ландфилл Сайт Менежмент Корпорэшн/ ашиглуулж болно гэж заасан боловч 35.2 дахь заалтаар дээрх эрхийг Төрийн байгууллагад хориглосон байдаг. Иймд Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой уг асуудлыг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай байна.

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА